

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 39.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Жонон даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгч Цээрэв овогтой Мөнхтүвшин, Гэлэн овогтой Лхамноржмаа, Намнан овогтой Оюун-Эрдэнэ нарын даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2.Хүчингүй болгосон даатгалын төлөөлөгчийн гэрчилгээ, үнэмлэхийг 2008 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Жонон даатгал” ХХК /Ш.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон даатгалын төлөөлөгчдийг Хорооны нэгдсэн бүртгэлээс хасахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ